

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/185 дугаар зүйлийн 185.3 дахь хэсэг:

“185.3. Хорих анги нь хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон шүүгчийн захирамжийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийн талаархи тодорхойлолтыг түүний оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлнэ” гэсэн зүйл, заалт нэмэх;

2/268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэг:

“268.2. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга нь хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн эрх эдэлнэ.”

2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “29.1.3,” гэсний дараа “29.1.4,” гэж, 214 дүгээр зүйлийн 214.7 дахь хэсгийн “цагдан хорих байр,” гэсний дараа “сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага,” гэж, 287 дугаар зүйлийн 287.8.3 дахь заалтын “хоригдолтой” гэсний өмнө “ялтан,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дараахь хэсгийг хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг:

“55.3. Шийдвэр гүйцэтгэгч хөрөнгийн үнэлгээний талаархи мэдэгдлийг үнэлгээ тогтоосон өдрөөс хойш 5 хоногийн дотор талуудад мэдэгдэж, санал хүсэлтийг авч, тэмдэглэл хөтөлнө.”

2/ 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг:

“59.1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200 дахин нэмэгдүүлсэн, эсхүл түүнээс дээш төгрөгтэй тэнцэх хэмжээний хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, эсхүл тэжээн тэтгэх үүргээ 1-ээс дээш жилийн хугацаагаар биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг дараахь үндэслэлээр түдгэлзүүлж болно:

59.1.1.эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн;

59.1.2.хөрөнгөө нуун дарагдуулсан;

59.1.3.төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор гадаад улсад оргон зайлж болзошгүй.

59.2.Энэ хуулийн 59.1-д заасан шийдвэр гарсан тохиолдолд төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан, эсхүл төлөөлөгчид түүний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх тухай мэдэгдэнэ.

59.3.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид, ахлах шийдвэр гүйцэтгэгч ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж шийдвэрлүүлнэ.

59.4.Төлбөр төлөгч албан ажлын, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар түр хугацаагаар гадаадад зорчих зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах шаардлагатай арга хэмжээ авсны үндсэн дээр төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түр сэргээнэ.

59.5.Гадаадад зорчсон төлбөр төлөгч Монгол Улсад буцаж ирээгүй, эсхүл иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанаас оргон зайлсан бол батлан даалт гаргасан этгээдийн барьцаанд тавьсан хөрөнгийг худалдан борлуулж төлбөр авагчийн шаардлагыг хангана.”

2/286 дугаар зүйлийн 286.7 дахь хэсэг:

“286.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн төв, суурин газраас алслагдсан хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 4 сар, баривчлах, саатуулах байр, цагдан хорих төв, цагдан хорих байр, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хаалттай хорих ангид 1 жил ажилласан хугацааг 1 жил 3 сар, нээлттэй хорих анги, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад 1 жил ажилласан хугацааг 1 жил 2 сар ажилласанд тооцно.”

4 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “185” гэснийг “188” гэж, 73 дугаар зүйлийн 73.5 дахь хэсгийн “Барьцаалагч-төлбөр авагчийн” гэснийг “Төлбөр авагчийн болон бусдын” гэж, 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсгийн “шийдвэр гүйцэтгэгчийн хөрөнгийн үнэлгээ тогтоосон шийдвэрийг” гэснийг “хөрөнгийн үнэлгээний талаархи мэдэгдлийг” гэж, 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсгийн “”шийдвэр гүйцэтгэгчийн үнэлгээ тогтоосон

шийдвэрт” гэснийг “хөрөнгийн үнэлгээний талаархи мэдэгдэлд” гэж, 189 дүгээр зүйлийн 189.13 дахь хэсгийн “тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн” гэснийг “зөвшөөрөл бүхий” гэж, 268 дугаар зүйлийн 268.1.4 дэх заалтын “хорих ял эдлүүлэхийг хойшлуулсан, тэнсэн сулласан ялтанд” гэснийг “тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 157 дугаар зүйлийн 157.1 дэх хэсгийн “, эсхүл нийтэд тустай ажил хийлгэх” гэснийг хассугай.

Гарын үсэг